

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2026/079/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх	
Сүхбаатар сум	Утас: 7036-3040	Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
2026 он	Ахлах аудитор:	Ц.Отгонбаяр
	Утас: 7036-3036	Цахим хаяг: Otgonbayarts@audit.gov.mn
	Ахлах аудитор:	Т.Болор
	Утас: 7036-2442	Цахим хаяг: bolort@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-12
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	13-17
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
4. Аудитын тайлан	18-19
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. Аудитын илрүүлэлт	20
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	21-22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН
ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА Т.ОДСҮРЭН ТАНАА

2026.02.25 № СЭА-2026/079/НА-СТА-ТКЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлд "Төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлнэ." гэж заасны дагуу "Аймгийн 2026 оны төсөв батлах тухай" тогтоолоор тус газрын орон тоо, цалингийн хязгаарыг бууруулж, баталсантай холбогдуулан 2 төрийн үйлчилгээний албан хаагчийг чөлөөлсөн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь

4326050052

харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 37 дугаар тогтоолоор байгууллагын нэршлийг “Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар” гэж өөрчилсөнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн А/53 дугаар захирамжаар байгууллагын дүрэмд өөрчлөлт оруулан, үйл ажиллагааны эрхэм зорилго, чиг үүрэгтэй уялдуулан орон тооны хязгаарт өөрчлөлт оруулалгүйгээр бүтцийг Дотоод аудитын хэлтэс, Санхүүгийн хяналт шалгалтын хэлтэстэй байхаар шинэчлэн баталсан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар нь тайлант онд 2 зорилт, 29 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 99.1 хувийн биелэлттэй тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ


2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан




Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	7,288,275.00	8,925,250.00
35	БАРАА МАТЕРИАЛ	7,288,275.00	8,925,250.00
35400	Хангамжийн материал	7,288,275.00	8,925,250.00
35410	Бичиг хэргийн материал	989,375.00	1,196,450.00
35420	Аж ахуйн материал	3,565,000.00	3,896,900.00
35440	Түлш, шатах тослох материал	370,000.00	1,500,000.00
35470	Бусад хангамжийн материал	2,363,900.00	2,331,900.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	56,121,218.96	54,751,521.65
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	56,121,218.96	54,751,521.65
39200	Биет хөрөнгө	51,996,218.96	51,526,521.65
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	57,894,700.00	76,294,700.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(19,325,379.32)	(34,077,503.35)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,695,600.00	13,683,600.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(5,268,701.72)	(4,374,275.00)
39300	Биет бус хөрөнгө	4,125,000.00	3,225,000.00
39301	Програм хангамж	5,380,000.00	5,380,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,255,000.00)	(2,155,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	63,409,493.96	63,676,771.65
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	63,409,493.96	63,676,771.65
51	Засгийн газрын хувь оролцоо	63,409,493.96	63,676,771.65
51200	Хуримтлагдсан үр дүн	63,409,493.96	63,676,771.65
51210	Өмнөх үеийн үр дүн	29,012,025.08	63,409,493.96
51220	Тайлант үеийн үр дүн	34,397,468.88	267,277.69
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	63,409,493.96	63,676,771.65

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан



Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	417,856,155.06	439,312,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15,535,800.00	439,312,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	15,535,800.00	150,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	15,389,800.00	-
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	146,000.00	150,000.00
122	Тусламжийн орлого	-	439,162,800.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	439,162,800.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	439,162,800.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	-	439,162,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	402,320,355.06	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	402,320,355.06	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	402,320,355.06	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	382,666,019.80	437,127,609.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	382,666,019.80	437,127,609.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	355,646,532.28	422,918,718.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	267,010,859.43	337,247,187.65
210101	Үндсэн цалин	106,500,195.55	166,667,006.01
210102	Нэмэгдэл	130,127,044.88	152,756,909.53
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,440,000.00	6,365,842.11
210104	Урамшуулал	18,943,619.00	11,457,430.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,710,936.11	40,666,923.07
210201	Тэтгэврийн даатгалын зардал	23,438,759.54	29,385,823.72
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	2,812,263.38	3,457,155.73
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	1,379,693.30	1,683,037.86
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	1,020,004.01	1,228,181.11
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	4,060,215.88	4,912,724.65
2104	Хангамж, бараа материалын зардал	10,899,597.00	11,606,824.00
210401	Бичиг хэрэг	2,237,425.00	2,291,250.00
210402	Тээвэр, шатахуун	5,480,000.00	4,720,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,274,722.00	2,197,649.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	907,450.00	857,650.00
210408	Бараа материал акталсны зардал	-	1,540,275.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,560,000.00	-
210604	Урсгал засвар	11,560,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	11,067,900.00	12,210,000.00
210702	Дотоод албан томилолт	11,067,900.00	12,210,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,626,000.00	756,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,000,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	626,000.00	648,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	108,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,771,239.74	20,431,784.03
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,931,000.00	2,580,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	12,840,239.74	17,851,784.03
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,019,487.52	14,208,890.28
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	11,458,890.28

21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	11,458,890.28
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	11,458,890.28
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	11,458,890.28
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,019,487.52	2,750,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7,424,687.52	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19,594,800.00	2,750,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	35,190,135.26	2,185,190.97
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	792,666.38	1,917,913.28
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	792,666.38	1,917,913.28
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(792,666.38)	(1,917,913.28)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	34,397,468.88	267,277.69



2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан



Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	402,320,355.06	439,162,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	439,162,800.00
122	Тусламжийн орлого	-	439,162,800.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	439,162,800.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	439,162,800.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	-	439,162,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	402,320,355.06	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	402,320,355.06	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	402,320,355.06	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	372,699,355.06	420,762,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	372,699,355.06	420,762,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	345,679,867.54	406,553,909.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	267,010,859.43	337,247,187.66
210101	Үндсэн цалин	129,628,900.00	166,667,006.01
210102	Нэмэгдэл	106,899,415.94	152,756,909.54
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,538,924.49	6,365,842.11
210104	Урамшуулал	18,943,619.00	11,457,430.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,710,936.11	40,666,923.06
210201	Тэтгэврийн даатгалын зардал	23,419,412.77	29,385,823.73
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	2,755,225.00	3,457,155.74
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	1,387,144.49	1,683,037.86
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	1,031,414.77	1,228,181.11
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	4,117,739.08	4,912,724.62
2104	Хангамж, бараа материалын зардал	12,220,272.00	12,713,799.00
210401	Бичиг хэрэг	2,708,800.00	3,244,000.00
210402	Тээвэр, шатахуун	5,424,000.00	5,700,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,970,022.00	2,197,649.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,117,450.00	1,572,150.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,112,900.00	380,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,552,900.00	380,000.00
210604	Урсгал засвар	11,560,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	11,067,900.00	12,210,000.00
210702	Дотоод албан томилолт	11,067,900.00	12,210,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,626,000.00	756,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,000,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	626,000.00	648,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	108,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,931,000.00	2,580,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,931,000.00	2,580,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,019,487.52	14,208,890.28
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	11,458,890.28
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	11,458,890.28
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	11,458,890.28

2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\		11,458,890.28
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,019,487.52	2,750,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7,424,687.52	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19,594,800.00	2,750,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	29,621,000.00	18,400,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	29,621,000.00	18,400,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	29,621,000.00	18,400,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	29,621,000.00	18,400,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	29,621,000.00	18,400,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(29,621,000.00)	(18,400,000.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан



Дансны код	Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	29,012,025.08	29,012,025.08
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	29,012,025.08	29,012,025.08
9	Тайлант үеийн үр дүн	-	-	34,397,468.88	34,397,468.88
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	63,409,493.96	63,409,493.96
11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	63,409,493.96	63,409,493.96
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	63,409,493.96	63,409,493.96
19	Тайлант үеийн үр дүн	-	-	267,277.69	267,277.69
20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	-	-	63,676,771.65	63,676,771.65

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан



Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	463,238,000.00	427,703,909.72	35,534,090.28	92.33
12	Татварын бус орлого	463,238,000.00	427,703,909.72	35,534,090.28	92.33
122	Тусламжийн орлого	463,238,000.00	427,703,909.72	35,534,090.28	92.33
122005	Төсвөөс санхүүжих	463,238,000.00	427,703,909.72	35,534,090.28	92.33
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	463,238,000.00	427,703,909.72	35,534,090.28	92.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	463,238,000.00	427,703,909.72	35,534,090.28	92.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	458,238,000.00	424,953,909.72	33,284,090.28	92.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	351,801,500.00	337,247,187.66	14,554,312.34	95.86
210101	Үндсэн цалин	170,867,900.00	166,667,006.01	4,200,893.99	97.54
210102	Нэмэгдэл	162,030,400.00	152,756,909.54	9,273,490.46	94.28
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,445,700.00	6,365,842.11	1,079,857.89	85.50
210104	Урамшуулал	11,457,500.00	11,457,430.00	70.00	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,975,100.00	40,666,923.06	3,308,176.94	92.48
210201	Тэтгэврийн даатгал	29,903,100.00	29,385,823.73	517,276.27	98.27
210202	Тэтгэмжийн даатгал	3,518,000.00	3,457,155.74	60,844.26	98.27
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,759,000.00	1,683,037.86	75,962.14	95.68
210204	Ажилгүйдлийн даатгал	1,759,000.00	1,228,181.11	530,818.89	69.82
210205	Эрүүл мэндийн даатгал	7,036,000.00	4,912,724.62	2,123,275.38	69.82
2104	Хангамж, бараа материалын зардал	17,773,400.00	12,713,799.00	5,059,601.00	71.53
210401	Бичиг хэрэг	5,405,700.00	3,244,000.00	2,161,700.00	60.01
210402	Тээвэр, шатахуун	5,850,000.00	5,700,000.00	150,000.00	97.44
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,600,800.00	2,197,649.00	403,151.00	84.50
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,916,900.00	1,572,150.00	2,344,750.00	40.14
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,465,000.00	18,780,000.00	5,685,000.00	76.76
210601	Багаж, техник, хэрэгсэл	24,465,000.00	18,780,000.00	5,685,000.00	76.76
2107	Томилолт, зочны зардал	12,300,000.00	12,210,000.00	90,000.00	99.27
210702	Дотоод албан томилолт	12,300,000.00	12,210,000.00	90,000.00	99.27
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,213,000.00	756,000.00	2,457,000.00	23.53
210803	Даатгалын үйлчилгээ	1,350,000.00	-	1,350,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	180,000.00	-	180,000.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	40,500.00	-	40,500.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,522,500.00	648,000.00	874,500.00	42.56
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	120,000.00	108,000.00	12,000.00	90.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,710,000.00	2,580,000.00	2,130,000.00	54.78
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,710,000.00	2,580,000.00	2,130,000.00	54.78
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,000,000.00	2,750,000.00	2,250,000.00	55.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,000,000.00	2,750,000.00	2,250,000.00	55.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,000,000.00	2,750,000.00	2,250,000.00	55.00
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	-	-	
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	-	-	
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	-	-	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	19.00	19.00	-	100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	9.00	9.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	8.00	8.00	-	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	9.00	9.00	-	100.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	6.00	6.00	-	100.00
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	2.00	2.00	-	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	1.00	1.00	-	100.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар /цаашид Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар гэх/ нь “Эрсдэлд суурилсан, бодитой баталгаажуулалт, зөвлөгөө болон бүрэн дүүрэн ойлголтоор хангах замаар байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх ба хамгаалах” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулжээ.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/279 дүгээр захирамжаар баталсан “Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дүрэм”-ийн 5.1-д тус албаны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, гэрээг мөрдөж байгаа байдал, хэрэгжилтийн хяналтыг байгууллагын дотоод хяналт болон засаглалд аудит хийх,
- Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, бүртгэл, зарцуулалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих,
- Эрсдэлийн удирдлагын тогтолцооны үр ашигтай байдалд аудит хийх,
- Төсвийн хөрөнгөөр санхүүжүүлж байгаа хөтөлбөр, төсөл, арга хэмжээний зарцуулалт, үр ашигтай байдалд хяналт тавих,
- Төсөв, санхүүгийн холбогдолтой хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм, журам, заавар, стандарт, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих,
- Төсвийн буюу төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагын өглөг, авлагын байдалд хяналт тавих,
- Тухайн байгууллагын орлогын төлөвлөлт, төвлөрүүлэлт, төсвийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих,
- Засгийн газрын тусгай зориулалтын сан, төсвөөс олгосон санхүүгийн тусламж дэмжлэг, эргэж төлөгдөх нөхцөлөөр ашиглуулж байгаа төсвийн хөрөнгө, олон улсын байгууллага, гадаад орны Засгийн газар, байгууллага, иргэдээс олгосон зээл, өгсөн хандив, тусламж, тэдгээртэй адилтгах хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад хяналт тавих,
- Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашгийн байдалд хяналт тавих.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- 2025 оны 07 дугаар сарын 09-ны өдөр Монгол Улсын Төсвийн тухай хуульд төсөв, хариуцлагатай холбоотой, Төрийн албаны тухай хуульд хариуцлагатай холбоотой нэмэлт өөрчлөлтүүд тус тус орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.1, 13.1.2 дахь заалтыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,

- Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосныг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсээс сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан төсвийн дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус газар нь аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан аймгийн ТЕЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагууд “Сэлэнгэ аймгийн төсөвт байгууллагууд дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 267.3 мянган төгрөгөөр буюу 0.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1

Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Бараа материал	7,288.3	8,925.3	1,637.0
Үндсэн хөрөнгө	56,121.2	54,751.5	(1,369.7)
Нийт хөрөнгө	63,409.5	63,676.8	267.3
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	63,409.5	63,676.8	267.3
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	63,409.5	63,676.8	267.3

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Бараа материалын дансны үлдэгдэл 8,925.3 мянган төгрөг болж, 1,637.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 12,021.2 мянган төгрөгийн материал худалдан авч, шатахууны урамшуулалд 150.0 мянган төгрөгийн талон хүлээн авч, 8,843.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 1,540.3 мянган төгрөгийн материалыг газрын даргын 2025 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн А/20 дугаар тушаалаар акталж устгасантай холбоотой,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 54,751.5 мянган төгрөг болж, 1,369.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 18,400.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж худалдан авсан, аймгийн ИТХ-ын 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 29 дүгээр “Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай” тогтоолоор 5,012.0 мянган төгрөгийн тавилга, хэрэгслийг Сүхбаатар сумын ЗДТГ, аймгийн ОНӨГ-т шилжүүлснээс шалтгаалсан байна.

Биет бус хөрөнгө: Тус байгууллагын санхүүгийн тайланд 2019, 2024 онуудад ашиглалтад орсон 5,380.0 мянган төгрөгийн санхүүгийн программ, цахим хаяг бүртгэлтэй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 744,885.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос олгох НДШ-ийн зардлыг 197,179.6 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 8,000.4 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 38,340.3 мянган төгрөгөөр, томилолтын зардлыг 12,300.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 357.0 мянган төгрөгөөр бараа үйлчилгээний бусад зардлыг 4,710.0 мянган төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийн зардлыг 20,760.0 мянган төгрөгөөр зэрэг нийт 281,647.2 мянган төгрөгөөр бууруулж, нийт 463,238.0 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 463,238.0 мянган төгрөгийн төсөв баталж, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөн, гүйцэтгэлээр 439,162.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 427,703.9 мянган төгрөг буюу 92.3 хувьтай тайлагнагдсан нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 33,284.1 мянган төгрөгөөр хэмнэснээс голлон шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/						
д/д		Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
70429 Санхүүгийн хяналт, дотоод аудит, эрсдэлийн удирдлага						
1	80801	Үндсэн үйл ажиллагааны зардал	458,238.0	424,953.9	33,284.1	92.7
2	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	5,000.0	2,750.0	2,250.0	55.0
Дүн			463,238.0	427,703.9	35,534.1	92.3

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн хүрээнд тус байгууллагаас авсан судалгааны үр дүн байдалтай байна. Үүнд:

- Тус байгууллагын даргын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн А/01 дүгээр тушаалаар унаа 2.0 мянган төгрөг, хоолны хөнгөлөлтийг өдрийн 4.0 мянган төгрөгөөр тогтоож, тайлант онд 6,365.8 мянган төгрөгийг тооцож олгосон,
- Тайлант онд нийт 9 орон тоо, 351,801.5 мянган төгрөгийн цалингийн сан батлагдсанаас гүйцэтгэлээр 9 албан хаагчид 337,247.2 мянган төгрөгийн цалин, нэмэгдлийг тооцож олгосон,
- Гадаад томилолт, төрд учирсан хохирлыг барагдуулах, сургалт, семинар, хурал, зөвлөгөөнтэй холбоотой зардал гараагүй, хэвлэл мэдээллийн байгууллагатай гэрээ байгуулж, ажил үйлчилгээ гүйцэтгүүлээгүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130051416 тоот дансанд тайлант онд орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тус байгууллага нь жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, батлуулаагүй бөгөөд тайлант онд шууд худалдан авах босго үнээс давсан худалдан авалт хийгдээгүй, тухай бүр гэрээ байгуулж, худалдан авалтыг хийж, гүйцэтгэсэн байна.



4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Болор гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ц.Отгонбаяр, дарга, тэргүүлэх аудитор Б.Батмөнх нар хэрэгжүүлсэн.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 382,566.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 3,825.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, тайлант оны батлагдсан төсвийг 35,534.1 мянган төгрөгөөр хэмнэж, ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор

www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын мэдээлбэл зохих 29 төрлийн 182 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль, тогтоомжтой нийцсэн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2025 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 431 дүгээр “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн.

Завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 03 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгийн данстын хувьд хэрэгжүүлсэн горим, сорил хэрэгжүүлсэн. Завсрын аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил илрээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа¹, зөрчил² илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл



Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй			
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дүн												

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Үүнээс

Албан тушаалтны тоо

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал



/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Дүн						
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Дүн						
Нийт дүн						